

**“БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙГ 2023-2028 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД 2023 ОНД ХИЙЖ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн “Засаглалын бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны XI/03 дугаар тогтоолоор “Булган аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулан 2023 онд хийсэн ажлын 10 сарын байдлаар явцыг тайлагнаж байна.

Тус хөтөлбөрийг аймгийн хүний нөөцийн хүрээнд үндсэн 3 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1. Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх
2. Төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх
3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахаар тусгаж доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зохион байгуулсан ажил	Үнэлгээ
1.1.	Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг орон нутгийн бодлогоор сургах, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах:	Булган аймагт дутагдалтай байгаа мэргэжлийн судалгаа гаргах ажлыг сум, байгууллагын түвшинд гаргаж, тэр хүрээнд ирэх 5 жилийн хүний нөөцийн судалгаатай болгох ажлууд хийгдэж байна. Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги төгссөн суралцагчдаас 45 хүүхдэд 161 сая төгрөгийн тэтгэлэг, 36 хүүхдэд 97.3 сая төгрөгийн дэмжлэг олгож, БНСУ-ын Шинхан их сургуульд сумдын захиалгаар 20 оюутныг 4 жилийн хугацаатай 100 тэтгэлэгээр, ОХУ-ын Буриад улсын ХАА-н их сургуульд 8 суралцагч, Беларусь улсад 3 оюутныг 100 тэтгэлэгээр сургаж байна. Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13, дунд хугацааны давтан сургалтад 19, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 10, эрхэлсэн түшмэлийн сургалтад 1 албан хаагчийг сургаад байна. Нягтлан бодогч болон архивын мэргэшүүлсэн сургалтад 15 албан хаагчийг хамруулаад байна.	100
1.2.	Төрийн захиргааны албан хаагчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангасан хүний нөөцийн санг сум, байгууллага бүр бий болгон хүний нөөцийн бүрдүүлэлт хийх	Төрийн албаны ерөнхий шалгалтыг 227 иргэнийг хамруулан 3 удаа зохион байгуулж, 85 иргэн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн нь нийт оролцсон иргэдийн 47,4 хувь болсон байна. Тусгай сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулж, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд 81 иргэнийг томилсон байна. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Шүүр” ажиллагааны хүрээнд аймгийн төрийн албан хаагчдаас 117 зөрчил илэрснээс 69 зөрчлийг арилгуулж, 48 зөрчлийг арилгуулахаар ажиллаж байна.	80
1.3.	Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд орон нутагт шаардлагатай байгаа мэргэжил сонгон авч суралцуулах чиглэлээр уулзалт, мэдээлэл хийх, их дээд сургууль төгсөх оюутнуудтай уулзалт хийх, сум,	Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн 230 суралцагчдад АНУ-ын элчин сайдын яамнаас АНУ-д сурах боломж, сурах визны талаарх мэдээлэл, Глобал удирдагч их сургуулиас Тайвань улсад тэтгэлэгээр сургах боломжийн талаар мэдээлэл тус тус өгч, 27 оюутанд тус бүр 2 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг авах эрхийн бичиг гардуулсан бол Орхон аймгийн Эрдэнэт их сургуулиас инженер техникийн дунд мэргэжлийн ажилтнуудыг ахисан түвшний бакалаврийн болон магистрийн сургалтад хамруулах сургалтыг тус тус зохион байгууллаа.	90

	байгууллага, орон нутгаа сурталчлах үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах	БНСУ-ын Сон-Э эмнэлэг болон АШУҮИС болон Этүгэн анагаах ухааны дээд сургуультай гэрээ байгуулж сургагчдыг ЕБС-ийн төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх сургалтанд хамруулахад нь дэмжлэг үзүүлэх боломжтой боллоо.	
1.4.	Хүний нөөцийн ил тод байдлыг сайжруулж, өрсөлдөх тэгш боломжоор ханган төрийн албаны сонгон шалгаруулалтыг ил тод зохион байгуулж сурталчилах	Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”-ын дагуу 1 удаа, 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол, шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 2 нийт 3 удаа зохион байгуулсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд нийт 121 иргэнийг тусгай шалгалт, сонгон шалгаруулалтын дүнгээр томилуулахаар эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх тогтоолыг хүргүүлсэн. Тогтоолын хэрэгжилт 89,5 хувьтай байна. Авлигатай тэмцэх газарт урьдчилсан мэдүүлэг хянуулахаар хүргүүлж, хариу хүлээгдэж байгаа 4 нэр дэвшигчийн одоогоор хүлээгдэж байна.	90

2. Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, чадавхижуулах чиглэлээр:

2.1.	Төрийн байгууллага бүр “Төрийн албан хаагчийн сургалт”-ын төлөвлөгөөг боловсруулан, үр дүнтэй хэрэгжүүлэх	Төрийн албаны тухай хуулийн 55.1 дэх заалтыг үндэслэн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан, санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг “4-7-10” сургалтад 2023 оны 10 сарын байдлаар давхардсан тоогоор 205 байгууллагын давхардсан тоогоор 6000 гаруй албан хаагч оролцож, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. Засгийн газар, холбогдох салбарын яам, удирдах дээд шатны чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад 6000 гаруй албан хаагч давхардсан тоогоор хамрагдлаа.	50
2.2.	Төрийн албан хаагчдыг боловсролын зэрэг ахиулах нөхцөл боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэх	Төрийн албан хаагчдыг боловсролын зэрэг ахиулах, мэргэшлээ дээшлүүлэхэд сургалтад хамрагдахад нь 13 албан хаагчид 24.5 сая төгрөгний сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна. (Эрүүл мэндийн чиглэлээр 2, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд 8, магистрын түвшний 3)	90
2.3.	Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох үйл явцад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Ухаалаг засаг” ТББайгууллагаас “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-ийн тухай танилцуулга, хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэх, хяналтанд авах, хуваарилах баталгаажуулах, үнэлэх” тухай зэрэг асуудлаар, “Боловсролын судалгаа арга зүйн чадвар төв”-ийн ТББайгууллага “Эерэг хандлага” сургалт, Төрийн захиргааны албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний карьер хөгжлийн төлөвлөлт, сургалтыг бусад Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа.	50
2.4.	Байгууллага бүр албан хаагчдын эрүүл мэндийг дэмжиж, жил бүр үзлэгт хамруулж, бие бялдрыг	Төрийн байгууллагын нийт албан хаагчийн 73,3 хувь нь эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд элэгний хавдар, цирроз, өөхлөлт, бөөр, давсагны үрэвсэл, уйланхай, нойр булчирхайн аргаг үрэвсэр, цэсний хүүхдийн үрэвсэл илэрсэн байна.	70

	чийрэгжүүлэх арга хэмжээг тогтмолжуулах		
2.5.	Орон нутгийн хэрэгцээ, хөгжлийн онцлогт тулгуурлан мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх баг байгуулан ажиллуулах	Төрийн захиргааны чиглэлээр ХХҮГ-ын ахмадын зөвлөх үйлчилгээг авч ахмад ажиллагсдаар зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа бол Ахмад багш нарын, Хөдөө аж ахуйн салбарт тариаланчдын болон мал аж ахуйн мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх багууд ажиллаж байна.	50
2.6.	Төрийн албыг салбар бүрээр чадавхижуулах, туршлага судлуулах, мэдээлэл, мэдлэг авах нөхцөл бололцоог бий болгох	Буриад улсад мал эмнэлгийн салбарын 14 ажилтан, Солонгос улсын Төрийн албаны сургалтын байгууллага "LOGODI" академид 2 төрийн албан хаагч, сумын ЗДТГ-ын дарга нар, Тайвань улсад 2 төрийн албан хаагч тус тус сургалтад хамрагдсан байна. Нийт 32 албан хаагчдад 25 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	90
2.7.	Төрийн албан хаагчдын чөлөөт цагийг өнгөрүүлэх хүрээнд салбар дундын болон салбар хоорондын урлаг спортын арга хэмжээг зохион байгуулан идэвхижүүлэх арга хэмжээг тогтмолжуулах	Аймгийн ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөлөөс хамтран жил бүрийн 11 сарыг "Төрийн албан хаагчдын сарын аян болгон илтгэх урлаг, "Батак" тэмцээн, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээнүүдийг, сумын ЗДТГ-ууд хойд урд бүсийн төрийн албан хаагчдын олон төрөлтийн мэтцээнүүдийг тогтмол зохион байгуулж байна. Мөн багш нарын спорт, урлагийн наадам, сумдын төрийн албан хаагчдын зөвлөгөөнүүд зэрэг олон ажлыг хийж тогтмолжиж байна.	100

3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр.

3.1	Төрийн байгууллагууд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах	Төрийн албаны тухай хуулийн 55.3 заасаны дагуу сум, агентлаг бүр Сургалт нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан ажиллаж байгаа ба жил бүр шаардагдах хөрөнгийг төсөвтөө суулгаж байна. Төрийн албан тухай хуулийн 59, 60, 61 дүгээр заалтын дагуу албан хаагчдад 850,0 сая төгрөг зарцуулаад байна.	100
3.2.	Байгууллага бүр албан хаагчдын эрүүл мэндийг дэмжиж, жил бүр үзлэгт хамруулж, бие бялдрыг чийрэгжүүлэх арга хэмжээг тогтмолжуулах	Төрийн байгууллагын нийт албан хаагчийн 73,3 хувь нь эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд элэгний хавдар, цирроз, өөхлөлт, бөөр, давсагны үрэвсэл, уйланхай, нойр булчирхайн аргаг үрэвсэр, цөсний хүүхдийн үрэвсэл илэрсэн байна.	70
3.3.	Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, ая тухтай ажиллах орчинг бүрдүүлэх	Төрийн үйлчилгээний хамгийн анхан шатны үйлчилгээг үзүүлж байгаа багийн дарга нарыг зөөврийн компьютерээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, 15 багийн дарга, 5 багийн эмч нарт зөөврийн компьютерээр, 8 багийн даргыг мотоциклээр хангалаа. Мөн ЕБС-ийн багш нарыг зөөврийн компьютерээр хангах ажил үе шаттай хийгдэж байна. Бүрэгхангай, Тэшиг, Хангал, Дашинчилэн, Гурванбулаг сумын ЗДТГ-ууд чанарын мененжментийн тогтолцоог /ISO/ нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	80

		2023-2024 оны хэлэлцээрийг 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр шинээр баталж, эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзлэгийг зохион байгуулж, үзлэгийн дүн 87,4 хувьтай дүгнэгдэж, нийт 21 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 1079 ажилтан, албан хаагчийг мэдлэг мэдээллээр хангалаа.	
3.4.	Төрийн албан хаагчдад зохих хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт урамшуулал олгох журмыг батлуулан хэрэгжүүлэх	Аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2023 оны төсөвт өөрчлөлт оруулж, орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар нэмэгдүүлж, Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 100.000 төгрөгөөр нэмэгдүүлэн олгохоор шийдвэрлэлээ.	100
3.5.	Суманд ажиллаж байгаа эмч, багш болон бусад нарийн мэргэжлийн ажилтнуудад орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Орон нутагт ажиллаж, амьдрах залуучуудын нийгмийн баталгааг хангахад дэмжин 2023 онд Хангал, Хялганат тосгон, Сайхан, Бүрэгхангай, Тэшиг, Булган сумдуудад 30 гаруй албан хаагч орон сууц, газар, гэр зэрэг буцалтгүй тусламжаар хангагдсан байна. 2023 оны байдлаар 140 айлын орон сууц ашиглалтад ороод байгаагийн 15 хувь сумдад ашиглалтад орсон байна. Мөн сумын төвүүдийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээг ашиглан нийтийн болон амины орон сууц барих аж ахуй нэгж, компаниудыг бодлогоор дэмжих ажлууд хийгдэж байна.	30
3.6.	Сумдад ашиглагдаж байгаа болон ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтын болон өмчлөлийн асуудлыг шийдэж, төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц болгох ажлыг судлаж шийдвэрлэх	Орон нутагт ажиллаж, амьдрах залуучуудын нийгмийн баталгааг хангахад Хангал, Хялганат тосгон, Сайхан, Бүрэгхангай, Тэшиг, Булган сумдуудад 30 гаруй албан хаагч орон сууцтай болсон байна. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 450-550 айлын орон сууц барихаар төлөвлөгдсөн ба 2021-2023 оны байдлаар 140 айлын орон сууц ашиглалтад ороод байгаагийн 15 хувь сумдад ашиглалтад орсон байна. 2023-2027 онуудад 300-350 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд үүний 30-аас багагүй хувийг хөдөө орон нутагт барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн сумын төвүүдийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээг ашиглан нийтийн болон амины орон сууц барих аж ахуй нэгж, компаниудыг бодлогоор дэмжин ажиллаж байна.	20

Хөтөлбөрийн хэрэгжилт /биелэлтийн дундаж хувь/	Нийт зорилт	1.1	1.2	1.3	1.4	2.1	2.2	2.3	2.4	2.5	2.6	2.7	3.1	3.2	3.3	3.4	3.5	3.6	Нийт үнэлгээ
	Үнэлгээ	100	80	90	90	50	90	50	70	50	90	100	100	70	80	100	30	20	74.7

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				Тухайн онд зарцуулсан төсөв
		Суурь үзүүлэлт 2022 он	2023 онд хүргэх	2023 онд хүрсэн түвшин	Хувь /тайлбар/	
Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх						
	Хүний нөөцийн 5 жилийн судалгаатай байгууллагын тоо	20%	50%	80%	2023 онд төрийн захиргааны 58, Төрийн тусгайлсан чиг үүргийн 4, төрийн үйлчилгээний 85 нийт 147 байгууллага төрийн үйлчилгээ үзүүлж байна. Нийт төрийн албан хаагчдаас улс	

					төрийн 126, төрийн захиргааны 592, төрийн тусгай 34, төрийн үйлчилгээ 3385 нийт 4137 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн албан хаагчийн тоо өмнөх үеийнхээс 1.3 хувиар өссөн үзүүлэлтэй, нийт ажиллаж хүчний 0.18 хувь нь төрийн албанд ажиллаж байна. 2023 онд төрийн албан хаагчийн 35 хүртэл насны албан хаагчдын эзлэх хувь 33.8 хувь бол 64,3 хувь нь 36-60 насны, 60 болон түүнээс дээш насныхан 1,9 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал 35 хүртэл насны албан хаагчдын эзлэх хувь /38,3/ 1,2 хувиар буурч, 36-60 насны албан хаагчдын эзлэх хувь /60,3/ 0.9 хувиар, 60 болон түүнээс дээш насныхны эзлэх хувь/1,3/ 1,8 нэмэгдсэн хувиар нэмэгдсэн байна.	
2	Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр гэрээ байгуулан тэтгэлгээр суралцаж байгаа оюутны тоо (гадаад дотоодод)	33	38	112	Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги төгссөн суралцагчдаас 45 хүүхдэд 161 сая төгрөгийн тэтгэлэг, 36 хүүхдэд 97.3 сая төгрөгийн дэмжлэг олгож, БНСУ-ын Шинхан их сургуульд сумдын захиалгаар 20 оюутныг 4 жилийн хугацаатай 100 тэтгэлэгээр, ОХУ-ын Буриад улсын ХАА-н их сургуульд 8 суралцагч, Беларусь улсад 3 оюутныг 100 тэтгэлэгээр сургаж байна	258,3 сая
3	Төрийн захиргааны албаны хүний нөөцийн хангалт	80%	85%	89.5%	Нийт төрийн захиргааны албан тушаалын 89.5 хувийн нөөц бүрдүүлэлттэй байна.	-
4	Боловсролын салбарын хүний нөөцийн хангалт	95.1%	98%	96.3%	Англи хэл 5, Математик багш 2, дизайн тех эр 1, эм 1, физик 1, газар зүй 1, монгол хэл 1, хоол зүйч 4, сэтгэл зүйч 3, эмч 2, захирал 2, сургалтын менежер 1, дотуур байрны багш 1, нийт 25 багш дутагдалтай байна.	-
5	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт	85%	95%	90.1%	Их эмч 19, /нярайн эмч, хүүхдийн эмч, дүрс оношлогоо/ сувилагч 16, эх баригч 4, лаборант 7, бага эмч 2, багийн бага эмч 9 нийт 57 дутагдалтай байна.	-
6	Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийн хангалт	81.3%	95%	83.3%	Мал аж ахуйн мэргэжилтэн 3, газар тариалан 3, хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн 2 малын эмнэлэгийн улсын байцаагч 4, тархвар зүйч 12, хяналтын цэгийн дарга 1, нийт 26 дутагдалтай байгаа байна.	-
7	Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хангалт	54.2%	65%	62%	Бүжгийн багш 3, эрхлэгч 2, хөгжмийн багш 2, бүжигчин 1, хөгжимчин 1, бүжгийн багш 1, жүжигчин 1 нийт 11 мэргэжлийн ажилтан дутагдалтай байна.	-
Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, чадавхижуулах						
1	Чадахуйн зарчмаар албан тушаал дэвшин ажиллах болзол хангасан мэргэшүүлэх багц цагийн сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	35	40	48	100%	10.8 сая
2	Магистрын зэрэгтэй албан хаагчдын тоо	111	116	5	100%	12.5 сая

3	Докторын зэрэгтэй албан хаагчдын тоо	3			-	-
4	Гадаад сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо	2	6	9	100%	37 сая
5	Хамтран ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын тоо	4	6	11	100%	4.3 сая
Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
1	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ	1.6 тэрбум	1.7 тэр бум	850 сая	50%	
2	Төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэгт хамрагдсан төрийн албан хаагчийн тоо	57.3 сая	60 сая	36.5 сая	60.8%	48.5 сая
3	Техник тоног төхөөрөмжийн хангалтийн хувь	65%	70%	90%	100%	227.2 сая
4	Эрт илрүүлгийн үзлэгт хамруулж эмчлэн эрүүлжүүлсэн албан хаагчдын тоо	50%	60%	70%	73.3%	
5	Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, ажиллах нөхцлийг сайжруулсан байгууллагын тоо	7	9	11	100%	
6	Төрийн албан хаагчдад зохих хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт урамшуулал олгох журмыг батлуулан хэрэгжүүлэх	0	10		100%	605 сая
7	Суманд ажиллаж байгаа эмч, багш болон бусад нарийн мэргэжлийн ажилтнуудад орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх	0	17	6	35%	-
1.Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх - 90 2.Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэн, чадваржуулах - 68.7 3.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах - 66						
Нийт хэрэгжилт-74.7 хувийн хэрэгжилттэй байна.						1.203.600.00 төгрөг
ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ САНХҮҮЖИЛТ						

